

## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Номгон сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.Umnugovi@audit.mn](mailto:www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг  
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал

Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон 304 тоот  
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn  
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

НОМГОН СУМЫН ИТХ-ЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БУЛГАМАА  
ТАНАА

2022.02.22 № 82

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өмнөговь аймгийн Номгон сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Номгон сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-22 №82\с

02.02.2022

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

|                                                | Үзүүлэлт                                          | /сая төгрөгөөр/ |
|------------------------------------------------|---------------------------------------------------|-----------------|
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 2.9             |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 21.8            |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>24.7</b>     |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             |                 |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 24.7            |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>24.7</b>     |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 91.7            |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 78.5            |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>13.2</b>     |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | -17.9           |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>-4.7</b>     |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                 |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 29.4            |
|                                                | Тайлант оны үр дүн                                | -4.7            |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>24.7</b>     |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                 |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 73.2            |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 73.2            |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>0</b>        |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>0</b>        |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>0</b>        |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>0</b>        |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0               |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0               |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                 |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>66.8</b>     |
|                                                | Урсгал зардал                                     | 66.8            |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                 |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             |                 |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | 66.8            |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             |                 |

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Номгон сумын ИТХ-ын эрхэм зорилго нь: “Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэн бэхжүүлэх, сумын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн идэвхтэй оролцоо, хяналтад тулгуурлан шийдвэрлэх” гэж тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиглэл нь орон нутгийн өөрөө удирдах ёсны үйл ажиллагаа явуулдаг байна.

**Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авч байгаа арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.

### **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 10.5 сая төгрөгийн 24 мэдээллээс 24 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудалгүй байхгүй байна.

### **Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 3.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.7 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч алдааг дахин гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлэв.

#### **7.1 Залруулсан алдаа**

Байхгүй

#### **4.2 Албан шаардлага**

Төлөөлөгчдийн сургалт, тэмцээн зэрэг зардалд 2.7 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 онд батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

#### **7.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Тайлантай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Цалингийн зардал дансыг орлого үр дүнтэй тулган баталгаажуулахад 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан нь НББ-ийн тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг хэрэгжүүлэн алдааг дахин давтан гаргахгүй байх.

#### **2. Шилэн данс**

##### Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээлэлд дараа жилийн төсвийн төсөл мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор" заалтыг хэрэгжүүлэн алдааг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**7.3 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                 | <b>1</b>                |                |       |                            |

**7.4 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/сая төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн |     | Үүнээс    |     |               |     |                 |     |         |     |
|---|-----------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|   |                             |                      |     | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|   |                             | Тоо                  | Дүн | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| A | 1                           | 2                    | 3   | 4         | 5   | 6             | 7   | 8               | 9   | 10      | 11  |
| 1 | ТШЗ                         | 3                    | 3.4 | 0         | 0   | 0             | 0   | 1               | 2.7 | 1       | 0.7 |

|   |                 |          |            |          |          |          |          |          |            |          |            |
|---|-----------------|----------|------------|----------|----------|----------|----------|----------|------------|----------|------------|
| 2 | Төсөл, хөтөлбөр |          |            |          |          |          |          |          |            |          |            |
| 3 | ЗГТС            |          |            |          |          |          |          |          |            |          |            |
| 4 | ТТЗ             |          |            |          |          |          |          |          |            |          |            |
| 5 | ТЕЗ             |          |            |          |          |          |          |          |            |          |            |
|   | <b>НИЙТ</b>     | <b>3</b> | <b>3.4</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>1</b> | <b>2.7</b> | <b>1</b> | <b>0.7</b> |